



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 22 өдөр

Дугаар A/526

Булган сум

### Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны XIX/08 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 2.15 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн хэмжээнд их хэмжээний хур тунадас орсны улмаас “Алтаргана 2024” олон улсын XV наадмын үеэр ашиглагдах авто замд ихээхэн хэмжээний эвдрэл гэмтэл үүссэн тул яаралтай засварлах зорилгоор “Булган А33А” ТӨХК-тай шууд гэрээ байгуулсугай.

2. “Булган А33А” ТӨХК-тай 30,000,000 (гучин сая) төгрөгөөр шууд гэрээ байгуулах эрхийг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-д олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, эрх олгогдсон хөрөнгийг хууль тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, тайлагнахыг “Булган А33А” ТӨХК захирал (М.Мөнх-Эрдэм)-д үүрэг болгосугай.

3. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-д даалгасугай.

4. Дээрх ажлын хөрөнгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд батлагдсан “Алтаргана-2024” зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010704